



**“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИ**

***ТОМУУГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ВАКЦИН ХИЙХ ҮЙЛЧИЛГЭЭ  
ҮЗҮҮЛЭГЧИЙГ СОНГОХ ҮНИЙН САНАЛ АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ***

**Тендер шалгаруулалт  
гэрээний дугаар: ЭТТ/201901259**

## **Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

“Эрдэнэс-Тавантолгой” ХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **“Томуугаас урьдчилан сэргийлэх вакцин хийх”** үйлчилгээ үзүүлэгчийг сонгох цахим үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх үйлчилгээний техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2019 оны 12 сарын 04-ны 10:00 цагаас өмнө Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2019 оны 12-р сарын 04-ны өдрийн 10:30 цагаас Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8, Финанс төв, 5 давхрын хурлын өрөөнд нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичгийг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайт болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**“Эрдэнэс-Тавантолгой” ХК  
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
1 дүгээр хороо, Жигжиджав-8,  
Финанс төв, 5 давхар 503 тоот,  
Утас: 75055555 дотуур утас-506**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлд заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
  - 1.2. Тендерт оролцогч тухайн үйлчилгээнд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: *Ажилтнуудыг томуугийн вакцинд хамруулах ажлыг ЭМЯ-аас эрх авсан хуулийн этгээд эрхлэн гүйцэтгэнэ.*
  - 1.3. Дараах үндсэн тоног төхөөрөмжийг үйлчилгээ үзүүлэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд: **[Шаардлагагүй]**
2. Тендерийн иж бүрдэл
  - 2.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
    1. Үнийн санал;
    2. Тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл /хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлэх/ эсхүл эм ханган нийлүүлэх Аж ахуйн нэгж орсон тохиолдолд вакцин хийх эмнэлэгтэй гэрээ байгуулсан байна. /Гэрээг хавсаргах/
    3. Аж ахуйн нэгж байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээ /хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлэх/
    4. Вакцины лабораторын чанарын баталгаажуулалтын гэрчилгээ ирүүлэх/хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлэх/
    5. Компаний дэлгэрэнгүй танилцуулга ирүүлэх
    6. Татварын байгууллагын цахим тодорхойлолт /Тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар ирүүлэх ба тендер нээх хугацаанд өр төлбөр болон дутуу төлөлтгүй байх/
    7. Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт /Тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар/
    8. ШШГЕГ-ын тодорхойлолт /Тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар/
    9. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш тендер нь 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
    10. Магадлан итгэмжлэлийн гэрчилгээтэй байна. /Хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ/
    11. Дархлаажуулалтын чиглэлээр мэргэшсэн эмч нар болон вакцинаатор сувилагчтай байна.
      - Мэргэжлийн лиценз /Хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ./
      - Мэргэжил дээшлүүлсэн байдал, ажлын туршлага зэргийг тодорхойлох бусад бичиг баримтууд
    12. Төлбөрийн нөхцөл:
      - Урьдчилгаа төлбөр олгохгүй ба үйлчилгээ үзүүлсний дараа нэхэмжлэлийг хүлээн авч гэрээг дүгнэснээс хойш ажлын 14 хоногт шилжүүлнэ.
      - Төлбөрийг гүйцэтгэлээр төлнө.
3. Тендерийн үнэ
  - 3.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт үйлчилгээ хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үйл ажиллагааны хуваарьт үндэслэнэ.

- 3.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
- 3.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон үйл ажиллагааны хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
- 3.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 4. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 4.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш [30]<sup>1</sup> хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 5. Алдааг залруулах**
- 5.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
  - (б) үйл ажиллагааны үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үйл ажиллагааны үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
  - (в) нэгж үнийг үйлчилгээний тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 5.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 6. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 6.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 6.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 7. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 7.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

<sup>1</sup> Энэ нь үнийн саналыг үнэлэх, гэрээ байгуулахад хүрэлцэхүйц (жишээлбэл 14 хоног) хугацаа байна.

## Гурав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### А. ЕРӨНХИЙ ЗААЛТ

- |   |   |
|---|---|
| <b>1. Гүйцэтгэгч үйлчилгээ үзүүлэх</b>                                | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан үйлчилгээг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.   |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                                  | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.   |
| <b>3. Үйлчилгээ дуусгахаар төлөвлөсөн өдөр үйлчилгээ дууссан байх</b> | 3.1. Гүйцэтгэгч үйлчилгээг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан үйл ажиллагааны хуваарь болон төслийн менежерийн баталсан тодотгосон үйл ажиллагааны хуваарийн дагуу хийж гүйцэтгэн, үйлчилгээ дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.   |
| <b>4. Аюулгүй байдал</b>  | 4.1. Гүйцэтгэгч бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хариуцна.<br>4.2. Үйлчилгээ үзүүлэхэд байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь үйлчилгээтэй холбогдуулж байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| <b>5. Зааварчилгаа</b>  | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй.   |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>  | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

### Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- |                                     |   |
|-------------------------------------|---|
| <b>7. Үйл ажиллагааны хуваарь</b>   | 7.1. Гүйцэтгэгч нь үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан үйл ажиллагааны хуваарийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.<br>7.2. Үйл ажиллагааны хуваарийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь үйл ажиллагааны хуваарийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b> | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн үзүүлсэн үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа үйчилгээнд зөрчил, гологдол хайх, далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.  |
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b>  | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа <sup>2</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.  |

- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
10. **Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

11. **Үйл ажиллагааны хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үйл ажиллагааны хуваарийн тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үйл ажиллагааны хуваарь нь үйл ажиллагааны хөтөлбөрт нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үйл ажиллагааны хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
12. **Үйл ажиллагааны хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр үйлчилгээний арга барил, эсхүл үйл ажиллагааны хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үйл ажиллагааны хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үйл ажиллагааны хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
13. **Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>3</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

14. **Үйлчилгээ дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь үйлчилгээ дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер үйлчилгээ дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана.
15. **Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
16. **Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
17. **Гэрээг цуцлах**
- 17.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 17.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд

эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- (а) Үйл ажиллагааны хөтөлбөрт үйлчилгээ зогсоох тухай заагаагүй, түүнчлэн үйлчилгээ зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч үйлчилгээг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер үйлчилгээний явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
  - (г) захиалагч төслийн менежерийн гаргасан төлбөрийн мэдэгдлийн дагуу төлөх төлбөрийг уг мэдэгдлийг гаргасан өдрөөс хойш 48 хоногийн дотор төлөөгүй;
  - (д) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
  - (е) гүйцэтгэгч үйлчилгээний гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 17.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч үйлчилгээг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

**18. Гэрээг  
цуцалсан үед  
хийх төлбөр**

- 18.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн үйлчилгээний болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй үйлчилгээний гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй. Хэрэв захиалагчид төлөх төлбөрийн нийт дүн гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс хэтэрвэл, хэтэрсэн дүн нь гүйцэтгэгчээс захиалагчид төлөх ёстой өр болно.
- 18.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн үйлчилгээ болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, үйлчилгээний зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**19. Гүйцэтгэлээс  
чөлөөлөх**

- 19.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйлчилгээг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн үйлчилгээ болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн үйлчилгээний хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

## Дөрөв. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ<sup>4</sup>

- 2.1** Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: *Томуугаас урьдчилан сэргийлэх вакцин хийх үйлчилгээ үзүүлэх, ЭТТ/201901259* дугаартай харьцуулалтын тендер]
- 2.1** Ажил нь *[Эрдэнэс-Тавантолгой ХК-тай хөдөлмөрийн гэрээ, контрактын гэрээ байгуулсан ажилтнуудад вакцин хийх үйлчилгээ]*-ээс бүрдэнэ.  
Сонгогдсон хуулийн этгээдийн
- 3.1** Төслийн менежер нь:
- Эрдэнэс-ТаванТолгой ХК  
ЯТН-ийн эмч  
Г.Эрдэнэтуяа  
Утас: 7505-5555 Дотуур дагаар 1003  
И-мэйл: [erdenetuya.g@erdenestt.mn](mailto:erdenetuya.g@erdenestt.mn)
- 4.1** Үйлчилгээ эхлэх өдөр *[талууд гэрээнд гарын үсэг зурснаар]*
- Үйлчилгээ дуусгахаар төлөвлөсөн өдөр *[Үйлчилгээг дуусгаж талууд гэрээг дүгнэж гэрээ дүгнэсэн акт үйлдсэнээр]*<sup>5</sup>
- 7.1** Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын *[5]* хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
- 13.1** Алданги ногдуулах хэмжээ 0,5 хувь байна.
- 19.1** Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын *[хувь]*-иар тооцно.



## Тав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### Томуугийн урьдчилан сэргийлэх вакцин

#### 1. Үйлчилгээг авснаар хийгдэх ажил, зорилго, үндэслэл:

- 2019 оны эхний хагас жилийн байдлаар уурхайн яаралтай тусламжийн нэгжээр нийт 1124 ажилтан үйлчлүүлсэн бөгөөд өвчлөлийн байдлыг өмнөх онтой харьцуулахад өндөр байна. Иймээс ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих зорилгоор архаг хууч өвчтэй, дархлаа суларсан, гадаа хүйтэн нөхцөлд ажилладаг болон хүнд техниктэй ажилладаг ажилтнуудыг томуугийн вакцинд хамруулах шаардлагатай. Энэ нь ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих, томуугийн эсрэг дархлаа тогтоох зориулалттай.

#### 2. Нийлүүлэгчид тавигдах шаардлага:

##### 2.1. Гүйцэтгэгчид тавигдах ерөнхий шаардлагын жагсаалт:

- 360 ажилтныг томуугийн вакцинд хамруулах ажлыг ЭМЯ-аас эрх авсан хуулийн этгээд эрхлэн гүйцэтгэнэ./зөвшөөрөл эсхүл зөвшөөрөлтэй эмнэлэгтэй хийсэн гэрээг хавсаргах/
- Магадлан итгэмжлэлийн гэрчилгээтэй байна.
- Дархлаажуулалт чиглэлээр мэргэшсэн эмч нар болон вакциinator сувилагчтай байна. /эсхүл гэрээт эмнэлэгтэй байна/
- Дархлаажуулалтын эмч, вакциinator сувилагч, эмнэлгийн ажилтны цагийн хуваарийг урьдчилан зохион байгуулж үндсэн ажилтай нь давхардуулахгүйгээр зохион байгуулна.
- ДЭМБ-ын 2019-2020 онд дэлхийн хойд бөмбөрцөгт байрладаг улс орнуудад зориулан гаргасан “Вакцины омог, найрлагын тухай” зөвлөмжинд заасантай дүйцэхүйц байна:
  - Цэвэршүүлэн идэвхигүйжүүлсэн ханиад томууны вирусын А хэлбэрийн эсрэгтөрөгч CA/Brisbane/02/2018 IVR-190 /H1N1/
  - Цэвэршүүлэн идэвхигүйжүүлсэн ханиад томууны вирусын А хэлбэрийн эсрэгтөрөгч A/Kansas/14/2017 X-327 /H3N2/
  - Цэвэршүүлэн идэвхигүйжүүлсэн ханиад томууны вирусын Б хэлбэрийн эсрэгтөрөгч B/Maryland/15/2016 NYMC BX-69A бүхий зэрлэг вирусны омгийг найрлагандаа агуулсан ДЭМБ-ын шаардлага хангасан вакцинтай дүйцэхүйц байх.
- Үхүүлсэн, бүтэн вирионт вакцин байна.
- Томуугийн вакцин нь Европын улс орнуудад эсвэл БНСУ-д үйлдвэрлэгдсэнтэй дүйцэхүйц байна.

##### 2.2. Чанар, стандарт

- Монгол улсын стандартад нийцсэн байна.

#### 3. Шаардагдах баримт бичиг

##### 3.1. Гүйцэтгэх ажлууд, ажил үйлчилгээний үе шатны хуваарь:

- Вакцинжуулалтыг гүйцэтгэгчийн ажлын байранд ажилтнуудад эмчийн үзлэг хийж, вакцинжуулалтанд хамруулна.
- Вакцинжуулалтыг гэрээ байгуулснаас хойш компанийн ХАБЭА-н хэлтсээс гаргасан хуваарийн дагуу үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

## Найм. Жишиг маягт

### 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш [тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр: \_\_\_\_\_

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга: \_\_\_\_\_

Албан тушаал, нэр: \_\_\_\_\_

Хаяг: \_\_\_\_\_

## 2. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### БАТЛАВ.

#### ЗАХИАЛАГЧ

#### ГҮЙЦЭТГЭГЧ

_____	_____
(Гамга, тэмдэг)	(Гамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр]** (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний, барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “ажил” гэх) **[гэрээний үнийг тооогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс :  
Улсын төсвөөс: 200.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 200.... онд: \_\_\_\_\_ төгрөг;  
Орон нутгийн төсвөөс: 200.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 200.... онд: \_\_\_\_\_ төгрөг;  
Өөрийн хөрөнгө: 200.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 200.... онд: \_\_\_\_\_ төгрөг.
4. Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:  
Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт;  
Зураг;  
Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь<sup>6</sup>;  
Санхүүжилтийн хуваарь;

<sup>6</sup> Нэгж үнийн гэрээнд “үе шатны ажлын хуваарь” гэснийг “ажлын тоо хэмжээ” гэж солино.

Ажил гүйцэтгэх хуваарь;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>7</sup>.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

2. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
3. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.
4. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
5. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

---

<sup>7</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.